



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/19

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Архуст сумын Нарст 2 дугаар багийн төвд байрлах Эрүүл мэндийн төвийн халаалтын бага оврын уурын зууханд гарсан дэлбэрэлтийн улмаас барилгад үүссэн нуралт, эвдрэлийг сэргээн босгох зорилгоор "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль" -ийн 29.2 дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 34.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны 08 дугаар сарын 26-ны А/22 тоот тушаал, Аймгийн Онцгой комиссын 2016 оны 05 дугаар сарын 7-ны өдрийн 04 тоот хурлын тэмдэглэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 14 тоот хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх Архуст сумын Эрүүл мэндийн төвийн барилгын сэргээн босголтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараахи бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Алтансүх / ГХБХБГ-ын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга/


Нарийн бичгийн дарга: Ш.Оюун-Эрдэнэ / Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн /

Гишүүд: Б.Болормаа / ГХБХБГ-ын мэргэжилтэн /

Б.Сүх-Очир /Архуст сумын Засаг даргын орлогч /

С.Эрдэнэчимэг /Иргэний нийгмийн төлөөлөл/

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу явуулахыг ажлын хэсэг / Д.Алтансүх /-д даалгасугай.

ДАРГА  М.ХҮРЭЛБААТАР

My doc: Tushaal